



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/530

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөлд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Баянмөнх сумын цэцэрлэгийн барилгыг өргөтгөсөнтэй холбогдуулан цэцэрлэгийн эрхлэгчийн саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулсугай.

2.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд заасан 3 бүлэг байсныг 5, барилгын хүчин чадал 75 байсныг өөрчилж 125 болгосугай.

3.Өөрчлөлтийн талаарх мэдээллийг тус цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд тэмдэглэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ